

## 7

## МЭДЭЭЛЛИЙН ШИНЭТГЭЛ ДЭХ САНГИЙН БҮРТГЭЛ

## С.Эрдэнэбилэг

Монгол Улсын Санхүү эдийн засгийн сайдын баталсан Улсын секторын нягтлан бодох бүртгэлд холбогдох үндэсний заавар, журам ба аргачлал нь бүртгэх тайлагнах ажлыг горим, журмын талаас зааварласан агуулгатай байдаг бол, олон улсын стандарт нь үйл явдлын үр дүн буюу тайлангийн үзүүлэлтүүдийг хэрхэн илэрхийлэх асуудлыг стандартын түвшинд заасан байдгаараа онцлогтой.

Зээл нь санхүүгийн хөрөнгөөс давсан тохиолд сөрөг үр дагавар үүснэ. Энэ нь ирээдвйд буцааж төлөх өр, амлалттай юм. Аккруэл суурьт нягтлан бодох бүртгэлд амлалт үүрэг (инкамбранс) ба болзошгүй өрийг тодруулдаг.

Улсын төсвийн алдагдал 1998 онд дотоодын нийт бүтээгдхүүний 11.0, 1999 онд 10.9, 2000 онд 10.4 хувь болсон байна. Төсвийн алдагдлын 70-аас дээш хувийг гадаадын зээлээр хааж байна. Энэ нь төсвийн төлөвлөлтийг боловсронгуй болгох, орлого, зарлагыг уялдуулах, тэгэхдээ зарлагандаа орлогыг захируулах биш орлогодоо зарлагаа тохируулах арга зүйг баримтлах шаардлагатай болсон байна. Төр эдийн засагт зохицуулах нилээд өндөр үүрэгтэй, түүндээ зохицсон төсөвтэй, төсвийн зарцуулалтад тавих хяналт төвлөрсөн нарийн системтэй байх ёстой.

Өнгөрсөн хугацаанд Төсвийн байгууллагын эдийн засаг, санхүүгийн үр дүнгийн тайлагналыг ил тод, тодорхой болгох зорилгоор төсвийн байгууллагууд тайлан тэнцлээ нягтлан бодох бүртгэлийн аккруэль суурьт зарчмаар гаргах болов.

Сангийн бүртгэлийн талаар ЗГСБХорооноос тодорхойлсныг дурьдвал: *засгийн газрын нягтлан бодох бүртгэлийн тогтолцоо санд суурилан үйлдэгдэж зохион байгуулагдах ёстой. Сан бол санхүүгийн нягтлан бодох бүртгэлийн тусдаа нэгж адил бэлэн мөнгөний бүртгэлийн данс, бусад санхүүгийн нөөц, өр төлбөр ба үлдэгдэл өмч болон балансын хамт, түүний хязгаарлалт, тусгай дүрэм журмын дагуу тодорхой зорилгод хүрэх, онцгой үйл ажиллагаагаар бий болсон*

зорилгыг тусгаарлах зэрэг өөрчлөлтүүдэд дангаар балансыг тогтоон тодорхойлогдоно<sup>4</sup>. Дараахь хоёр нөхцлийг хангахыг шаардана. Нэгд, хөрөнгө тусгай зорилгоор хадгалагдах эдийн засгийн ба санхүүгийн тусдаа нэгж байх, хоёрт, санхүүгийн тусдаа нэгжид зориулан данс үүсгэсэн байгууллагын бүртгэл давхар бичилтийн зарчмаар бүртгэнэ. Өөрөөр хэлбэл санг мөнгөн хөрөнгө, санхүүгийн эх үүсвэр, өр төлбөр болон үлдэгдэл өмч хөрөнгийн тэнцэл, түүний өөрчлөлттэй, хууль журмаар хязгаарласан тусгай үйл ажиллагаа явуулах ажил гүйлгээг бүртгэхэд ашиглана.

Сан бүртгэлийн шинжлэх ухааны тулгуур зарчимд үндэслэдэг, тэгээд ч бүртгэлийн шинжлэх ухааны мэдлэгийн тогтолцоо өөрөө "бүртгэлийн философи-арга зүй-бүртгэлийн шинжлэх ухаан" гэсэн гурвалсан холбооноос бүрддэг. Засгийн газрын санхүүгийн тайлан зарцуулах бүрэн эрхэд нийцсэн, түүнийг дагаж гүйцэтгэж байх ёстой. Энэ зорилгоор санг тодорхойлно. Тухайлбал нэгдсэн орлогын сан, өрийн үйлчилгээний сан болон парламентийн зарцуулалтын бусад сан зэрэг хэд хэдэн төрлийн санг ашиглаж болно.

Засгийн газрын санхүүгийн тайлан бүрэн эрхээр хязгаарлагддаг. Сан ба нөөц /зарцуулалт/ нь өөр ойлголт юм. Сан бол хөрөнгө буюу актив, дебит талтай, нөөц ба төсвийн зарцуулалт нь /хуримтлагдсан ашгийн/ эх үүсвэр буюу пассив, кредит утгатай дүйх учиртай. Сангийн нягтлан бодох бүртгэл нь эдийн засгийн тусгаар нэгжийн нягтлан бодох бүртгэл гэсэн утгаараа хууль, журамд зааснаар нөөцөөр сан байгуулах, түүнд хэм хэмжээ, хязгаар тогтоосон зохион байгуулалт бүхий өвөрмөц хэлбэр мөн. Мөн нөөцийн ашиглалтыг тусгайлсан болон сангаас санд бүртгэх нь эдгээр хэм хэмжээнд захирагдаж байх ёстой.

Улсын болон орон нутгийн засаг захиргаа дараахь санг (балансанд өөрийн хөрөнгөөр) зарцуулах эрхээ харилцан адилгүй үүсгэж бүртгэнэ:

Засгийн газрын нөөц сан:

Тусламжийн орлогын сан – тусламжийн нөхцлөөр бий болсон орлогыг бүртгэх (хөрөнгө зарцуулалтын эрх нь хязгаарлагдмал), гэрээний амлалт үүрэг буюу инкамбрансын бүртгэл, Өрийн үйлчилгээний сан – үндсэн төлбөр, хүүгийн зардал, болзошгүй өр төлбөрийг бүртгэнэ.

Сан бол үүрэг хариуцлага барагдуулснаар байгууллагад үлдэх үнэ цэнэ, үлдэгдэл хувь, цэвэр активыг бүртгэх өмч хөрөнгө юм.

Төрийн сангийн тогтолцоонд нэгд, өрийн үйлчилгээний санд суурилсан мэдээлэл хувиргалтын загвар, хоёрт, сан төвтэй нягтлан бодох бүртгэлийн загварыг суулгаж өгөх нь зүйтэй. Алив онолын бүтцийг

<sup>4</sup> Засгийн газрын Бүртгэлийн Стандартын Хороо, Засгийн газрын кодчилал ба Санхүүгийн тайлангийн стандарт 1993, (АНУ), хэсэг, 1100.102.

хөгжүүлэх чухал хандлага элемент, ойлголтын хүрээг тогтоох явдал. Ашгийн бус байгууллага, түүний дотор гадаадын зээл тусламжийн орчны санхүүгийн хэмжил, тайлагналд хамгийн их холбогдох хөрөнгө, өр төлбөр /өрийн үйлчилгээ/, сан /өмч/, зээл тусламжийн хөрөнгө оруулалт ба хэрэглээ, орлого, зардал, олз, гарз гэсэн дотоод уялдаа бүхий 9 бүрдэл хэсгийн ойлголт, шинж ба шалгуурыг аккруэл суурийн хэрэглээтэй холбож шинээр тунхаглав.

Хөрөнгө өнгөрсөн үйл явцаар байгууллагын хяналтад орж, ирээдүйд үйлчилгээ, эдийн засгийн өгөөж авчрах нөөц, өр төлбөр үйлчилгээ, эдийн засгийн өгөөжийг өөртөө агуулсан, байгууллагын нөөцөөс хасагдах, өмнөх үйл явцаас улбаатай бусдын өмнө улсын хүлээх үүрэг хариуцлага, сан /өмч/ бол үүрэг хариуцлага барагдуулснаар улсад үлдэх үнэ цэнэ, үлдэгдэл хувь, цэвэр актив, зээл тусламжийн хөрөнгө оруулалт – улсын хөрөнгө, өмчлөх эрх, оролцоог нэмэгдүүлэхийн тулд гадаадын зээл тусламжаар оруулсан зүйлсээр цэвэр хөрөнгөд гарах өсөлт. Үр дагавар: хөрөнгө өсөх авч бас үйлчилгээ, эсвэл өр төлбөрийн барагдалт, хувиргалт байж болно. Улсын хэрэглээ – хөрөнгө шилжүүлэх, үйлчилгээ үзүүлэх, эсвэл үүрэг хариуцлага хүлээсний дүнд цэвэр хөрөнгөд гарах бууралт. Хэрэглээнд өгсөн хуваарилалтаар өмчлөх эрх, хувь оролцоо буурна.

Орлого бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээ гэх мэт хэвийн хувиргалтаар бий болох эдийн засгийн өгөөжийн дотогш урсгал бөгөөд байгууллагын хөрөнгө нэмэгдэж, өр төлбөр багасах, улмаар эздийн өмч нэмэгдэх үр дагавартай. Зардал бол бараа хүргэх, бүтээгдэхүүн үйлдвэрлэх, үйлчилгээ үзүүлэх зэрэг хэвийн хувиргалт, байнгын үйлдэлтэй холбогдсон гадагшлах мөнгөн урсгал бөгөөд байгууллагын хөрөнгө багасах, өр төлбөр нэмэгдэх, улмаар эздийн өмч хорогдох үр дагавартай. Олз /гарз/ гэж байнгын бус, тохиолдлын ажил гүйлгээ, тэрчилэн эздийн ба зээл тусламийн орлогоо, хөрөнгө оруулалтаас бусад бүх гүйлгээ, үйл явц, нөхцлийн үр дүнд байгууллагын өмч ба цэвэр хөрөнгөд гарсан өсөлт /бууралт/ гэсэн зарчмын томъёоллыг монгол бүртгэлийн технологид шинээр оруулж суулгах нь чухал байна.

**Өрийн үйлчилгээний сангийн тайлангийн загвар.** Гадаад өр төлбөрийн үндсэн шинж засгийн газрын байгууллагын өнөөгийн хүлээх үүрэг хариуцлага болно. Өр төлбөр гол төлөв хөрөнгө зээлж эсвэл авах тухай үл цуцлах гэрээ байгуулсан үед үүсч болно.

Аккруэл суурьт нягтлан бодох бүртгэл үүрэг хариуцлагын нөхцөл, хэрэгжилтийн хувь заяаг нягт судлаж, нийтээр зөвшөөрсөн ойлголт, шалгуурын нийцлийн төвшинг бодитой үнэлэхийг шаардах учир манайд төлбөрийн амлалт, үүрэг хариуцлага, болзошгүй өр төлбөр гэсэн түгээмэл ойлголтуудыг төгс зааглах нь чухал гэж үзэв. Төлбөрийн амлалт өнгөрсөн явцаас үүдэн хүлээгдэж буй улсын үүрэг хариуцлага. Төлбөрийн амлалт нийтээр зөвшөөрсөн ойлголт, шалгуурт илт тохирохгүй, нийцлийн төвшин туйлын доогуур учир аккруэл

сууриар хүлээн зөвшөөрөхгүй ч материаллаг шинжтэй бол санхүүгийн тайланд нэмж тодруулдаг.

Үүрэг хариуцлага төгс баталгаажих бол болзошгүй өр төлбөр гэсэн томъёолол үүснэ, баталгаажилт төгс биш бол аккруэл сууриар хүлээн зөвшөөрөх үндэсгүй, материаллаг шинжтэй бол зөвхөн санхүүгийн тайлангийн тодруулгад илэрхийлэх дүрэмтэй.

Өр төлбөрийн ойлголт, шинж, шалгуур зөрчилтэй, биелэхгүй, эсвэл эргэлзээтэй үед чухамдаа дээрх томъёолол үүсдэг. Шинж, шалгуур хангаж буй ч үүрэг хариуцлага улсын хяналтаас гадуур, өмнөх явцаас улбаатай ч үүрэг хүлээх нь эргэлзээтэй, эсвэл мөнгөн урсгал гадагшлах магадлал бага буюу эргэлзээтэй, бас найдвартай хэмжих боломжгүй. Аккруэл бүртгэлд нийтээр зөвшөөрсөн ойлголт, шинж, цогц бүрдсэн, бас шалгуур бүрэн хангасан нөхцөлд сая баримт, гүйлгээ, мөнгөн урсгалыг хүлээн зөвшөөрдөг.

Засгийн газар худалдан авалтын мэдээлэлд үндэслэж ирээдүйн өр төлбөрийг хүлээн зөвшөөрч болно. Энэ нөхцөлд зээлээр авсан гүйлгээ нь өр төлбөрийг үүсгэнэ. Зарим өр төлбөр урьдчилан таамгаар тооцсон болзршгүй өрийн дүнг өр төлбөр гэж үздэг.

Засгийн газрын нягтлан бодох бүртгэлийн хорооны стандартад Өрийн вйлчилгээний сангийн төрөл гэдэгт өрийн вйлчилгээнд зориулсан зардал ба урт хугацааны өрийн вйлчилгээг нэмэгдүүлэх орлого ба бусад санхүүгийн эх үүсвэрийг хэрхэн бүртгэхийг тайлбарласан байдаг.

Засгийн газрын гадаадын өрийн төрөлд тухайлбал үндсэн төлбөр, болзошгүй өр төлбөр болон хүүгийн төлбөр зэрэг орно.

Аккруэль суурьт бүртгэлээр амлалт үүрэг ба болзошгүй өрийг тодруулахад тохиромжтой. Урт хугацааны зээлийн үндсэн болон хүүгийн төлбөрт зориулан татвар болон тусгай үнэлгээгээр Өрийн вйлчилгээний санд онцгойлон татвар ноогдуулсан бол үүнийг Өрийн вйлчилгээний сангаас орлого гэж үзнэ.

ЗГНББСХорооны стандартын нэг онцлог зүйл нь өрийн вйлчилгээний бүртгэлд урт хугацааны өр төлбөрийн хүүг хуримтлуулдаггүй, хүү төлөгдөх хуулийн хугацаа буюу тухайн жилд нь зардлаар хүлээн зөвшөөрнө.

Өрийн вйлчилгээний санд ашиглах дансыг нөөцийг бүртгэх ялангуяа хүүгийн төлбөрийг бүртгэх дансыг ашигладаг.

Анхны үнээр буцаан төлөгдөх өр төлбөрийг тогтмол, эхний төлбөр нэг жилээс илүү хугацаагаар хойшлогдсон бол хойшлогдсон өр төлбөр, жилийн төлбөрийн буцаан төлөлт жил бүр нэмэгдэхээр төлөвлөж, ойролцоогоор хүүгийн төлбөр буурснаар (учир нь төлөлт багасч хүү буурснаар) жил тутмын тэнцүү хэмжээтэй вичилсэн өр төлбөр үүснэ. Тогтмол бус өр төлбөр бусад гурван төрөлтэй адилгүй, буцаан төлбөрийн хэв шинжтэй байна.

Тогтмол өр төлбөрийн бүртгэлийн жишээ нь IV-р ДЦС-ийн өр төлбөрт зориулсан үндсэн болон хүүгийн төлбөрийг төлөхөд үүссэн өрийн вйлчилгээний сангаар тайлбарлаж, тайлангийн загварыг үзүүлэв.

**“Засгийн газар”**  
**IV-р ДЦС-ын Өрийн вйлчилгээний сан**  
**Үлдэгдэл тэнцэл**  
**2000.12.31**

(сая ₮)

<b>Хөрөнгө</b>	
Мөнгө	₮ 36500
Авлага	2000
<b>Нийт хөрөнгө</b>	<b>₮ 38500</b>
<b>Сангийн өр төлбөр ба өмч</b>	
Өглөг	2000
Сангийн үлдэгдэл	₮ 36500
<b>Нийт сангийн өмч</b>	<b>₮ 38500</b>

**“Засгийн газар”**  
**IV-р ДЦС-ын Өрийн вйлчилгээний сан**  
**Орлого, үр дүнгийн тайлан**  
**2000.12.31**

<i>Орлого:</i>		
<b>Ерөнхий сан-Шилжүүлэг</b>		<b>₮204000</b>
<i>Зардал:</i>		
Үндсэн өр	120000	
Зээлийн хүү	96000	
<b>Нийт зардал</b>		<b>216.000</b>
Зөрүү ашиг (алдагдал)		(12.000)
Сангийн үлдэгдэл, 2000.01.01		12.000
Капитал төслийн сангаас өмч шилжүүлэг		38500
<b>Сангийн үлдэгдэл, 2000.12.31</b>		<b>₮38500</b>

Засгийн газрын байгууллага хэд хэдэн өрийн вйлчилгээний санг ашигладаг бол зэрэгцүүлсэн санхүүгийн тайлан гаргах ёстой. Дөрвөн төрлийн өрийн вйлчилгээний сангийн Зэрэгцүүлсэн үлдэгдэлийг гэрээ ба хууль тогтоомжийн дагуу хийж гаргасныг харуулав.

**“Засгийн газар”  
IV ДЦС-ын  
Өрийн үйлчилгээний сан  
Зэрэгцүүлсэн үлдэгдэл  
тэнцэл  
2000.12.31**

(сая ₮)

	Орон нутгийн өрийн үйлчилгээ			Хотын өрийн үйлчилгээ	Нийт өрийн үйлчилгээний сан
	Нэгтгэсэн өр			Нэгтгэсэн өр	
	ДЦСтанц	Харилцаа холбоо	Уул уурхай		
<b>Хөрөнгө</b>					
Мөнгө .....	₮30176	₮87698	₮17308	₮114832	₮250014
Мөнгө, санхvv/байгууллага	1930544	--	82480	116019	2129043
Хөрөнгө оруулалт	11167467	7983789	1302536	8629059	29082878
Нэмэгдсэн хvвгийн авлага	187733	44393	124188	164602	520916
Бусад сангаас хураамж	27422	2210	--	--	29623
Татварын авлага	523942	--	--	242756	766698
<b>Нийт хөрөнгө</b>	<b>₮13867284</b>	<b>₮8118090</b>	<b>₮1526539</b>	<b>₮9297268</b>	<b>₮32779181</b>
<b>Өр төлбөр ба сангийн өмч</b>					
<i>Өр төлбөр:</i>					
Дансны өглөг	706	7	--	1708	2421
Бусад санд хураамж	688938	--	--	1	688939
Хойшлогдсон орлого	523942	--	--	242756	766698
<b>Нийт өр төлбөр</b>	<b>1213586</b>	<b>7</b>	<b>--</b>	<b>244465</b>	<b>1458058</b>
<i>Сангийн баланс:</i>					
Өрийн үйлчилгээнд	12653698	8118083	1526539	9022803	31321123
<b>Нийт сангийн баланс</b>	<b>12653698</b>	<b>8118083</b>	<b>1526539</b>	<b>9022803</b>	<b>31321123</b>
<b>Нийт өр төлбөр ба сангийн баланс</b>	<b>₮13867284</b>	<b>₮8118083</b>	<b>₮1526539</b>	<b>₮9267268</b>	<b>₮32779181</b>

**“Засгийн газар”  
IV ДЦС-ын Өрийн үйлчилгээний сан  
Орлог, үр дүнгийн тайлан  
2000.6.30**

(сая ₮)

	Орон нутгийн өрийн үйлчилгээ			Хотын өрийн үйлчилгээ	Нийт Өрийн үйлчилгээний сан
	Нэгдсэн бонд			Нэгтгэсэн өр	
	ДЦСтанц	Холбоо харилцаа	Уул уурхай		
<i>Орлого:</i>					
Татвар .....	₮8740740	₮ --	₮6537325	₮3849992	₮19128057
Хөрөнгө ашиглалтаас орсон орлого .....	5156620	668273	986052	2675808	9486753
Бусад засгийн газрын агентлагаас орлого	326298	--	--	--	326298
<b>Нийт орлого</b>	<b>₮14223658</b>	<b>668273</b>	<b>7523377</b>	<b>6525800</b>	<b>28.941108</b>
<i>Зардал:</i>					
<i>Өрийн үйлчилгээ:</i>					
Тэтгэврийн зардал	6650495	--	4849000	3049000	14548495
Хvв ба санхvвгийн төлбөр	6515348	2073750	2983586	2595120	14167804
<b>Нийт зардал</b>	<b>₮13165843</b>	<b>2073750</b>	<b>7832586</b>	<b>5644120</b>	<b>28716299</b>
<b>Орлого (алдагдал)</b>	<b>1057815</b>	<b>(1405477)</b>	<b>(309209)</b>	<b>881680</b>	<b>224809</b>
<i>Бусад санхvвгийн ашиглалт:</i>					
Бусад сангаас шилжvүлэг	168564	--	105858	873297	1147719
Бусад санд шилжvүлэг	(105858)	--	--	--	(105858)
Бусад санхvвгийн нийт ашиглалт	62706	--	105858	873297	1041861
Орлого (алдагдал) ба зардал давсан бусад ашиглалт	1120521	(1405477)	(203351)	1754977	1266670
Капитал төслийн сангаас эсвэл санд өмч шилжvүлэг	(687868)	9523560	--	--	8835692
Сангийн үлдэгдэл, С1	12221045	--	1729890	7267826	21218761
<b>Сангийн үлдэгдэл, С2</b>	<b>₮12653698</b>	<b>₮8118083</b>	<b>₮1526539</b>	<b>₮9022803</b>	<b>₮31321123</b>